



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/320

Улаанбаатар хот

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтэд цахимаар сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 3,200,000 /гурван сая хоёр зуун мянга/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ахлах нягтлан бодогч Б.Хонгорзулд зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлыг хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулан ажлын үр дүн, явц байдлын тайланг дүүргийн Засаг даргад танилцуулахыг Замын цагдаагийн хэлтэс /цагдаагийн хурандаа Ц.Ариунболд/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч С.Бямбадоржид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА